



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар A/125

Бор-Өндөр сум

**Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх
ажилд хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Аймгийн онцгой комиссын 2024 оны “Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай 01 албан даалгавар, Монгол Улсын Шадар сайдын 2024 оны оны “Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үер усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулахад 6,805,000 /Зургаан сая найман зуун таван мянган төгрөг/-ийн хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг сумын гамшгийн эрсдэлийн сангаас зохих журмын дагуу санхүүжүүлэхийг санхүү албаны дарга /Э.Түвшинсайхан/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ